



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/43/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Даланзадгад хот
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, агуулгын хоцрогдолыг арилгахын тулд сургууль, багш, эцэг эхийн хамтын оролцоотойгоор танхимын болон танхимын бус сургалтыг тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааны чиглэлтэй байна. Үүнд:

- Сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр чанартай, хүртээмжтэй тасралтгүй зохион байгуулах;
- Эцэг эх, багш, суралцагчдын хамтын ажиллагааг сайжруулж цахим орчинд хөгжиж, суралцах чадвараа ахиулах, хамтран суралцах, харилцан туршлага солилцох;
- Судлагдхууны хоцрогдол арилгах аргазүйн дэвтрийг бие даан ажиллуулах, хяналт тавих, зөвлөн туслах;
- “Хос бичигтэн-Өмнөговьчууд” хөтөлбөрийн хүрээнд багш суралцагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид цар тахалтай холбоотойгоор 2021 оны 3,9,10,11,12 саруудад сургалтын үйл ажиллагааг танхимаар явуулсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, агуулгын хоцрогдолыг арилгахын тулд сургууль, багш, эцэг эхийн хамтын оролцоотойгоор танхимын болон танхимын бус сургалтыг тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна” гэж заасны хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.



Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 168,100.6 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 140,401.2 мянган төгрөгийн санхүүгийн тайлагнал, бүртгэлтэй холбоотой 5 алдааг залруулж, 511.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 22.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 27,165.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн ба залруулагдаагүй 27,699.0 мянган төгрөгийн алдаа зөрчил, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 20,225.9 мянган төгрөгөөр давсан хэдий ч санхүүгийн тайлагналд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургууль	12	168,100.6	5	140,401.2	2	511.2	2	22.9	3	27,165.3